

 МИК ХОЛДИНГ <small>Транспорт компани</small>	“МИК ХОЛДИНГ” ХК Мэдээллийн ил тод байдлын бодлого Хувилбар 1.0 Төлөв: Батлагдсан		Баталсан огноо: 2021/03/19 
--	---	--	---

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
21/04 дугаартай тогтоолын Хавсралт №3
 1116216038.№.5221978
 УЛАНБААТАР ХОТ

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН БОДЛОГО

Баримт бичгийн нэр	Мэдээллийн ил тод байдлын бодлого
Хувилбарын дугаар:	1.0
Баримт бичгийн төлөв:	Хүчин төгөлдөр
Хэлэлцэж эцэслэсэн :	2021/03/12 (ОУСК-Ажлын хэсгийн хурал)
Батлагдсан:	2021/03/19 (Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 21/04 дугаартай тогтоол)
Эргэн хянах:	2022/03/20 (Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба)
Боловсруулсан нэгж:	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба
Хяналт тавих:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хамаарах нэгж:	Компанийн ТҮЗ, түүний дэргэдэх хороод, Гүйцэтгэх захирал, бүх газар нэгж, ажилчид

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбарын дугаар	Батлагдсан огноо	Товч утга	Боловсруулсан нэгж
1.0	2021/03/19	Анхны хувилбарыг хэлэлцэж батлав.	ТҮЗ-ийн ажлын алба

	“МИК ХОЛДИНГ” ХК	Төлөв: Батлагдсан
	Мэдээллийн ил тод байдлын бодлого	Хувилбар 1.0 Баталсан огноо: 2021/03/19

АГУУЛГА

1. Зорилго	III
2. Хамрах хүрээ	III
3. Бодлогын үндсэн зарчим.....	III
4. Компанийн нэрийн өмнөөс мэдэгдэл хийх	IV
5. Нээлттэй болгох мэдээлэл.....	IV
6. Хувьцаа эзэмшигчид мэдээлэл өгөх	IV
7. Компанийн дотоод мэдээлэл	IV
8. Хариуцлага	IV
9. Бодлогыг хэрэгжүүлэх.....	V

 МИК ХОЛДИНГ <small>ЗУРГҮҮЛЭЛТ СӨМӨНӨҮҮС</small>	“МИК ХОЛДИНГ” ХК <hr/> Мэдээллийн ил тод байдлын бодлого Хувилбар 1.0	Төлөв: Батлагдсан Баталсан огноо: 2021/03/19
---	--	---

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН БОДЛОГО

1. Зорилго

1.1. Мэдээллийн ил тод байдлын бодлого / цаашид бодлого гэх /-ийн зорилго нь Монгол улсын хууль, тогтоомж, зохицуулагч байгууллагаас гаргасан журам, засаглалын баримт бичгүүдэд нийцүүлэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, сонирхогч талууд болон олон нийтэд компани болон түүний бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв зохистой, ил тод хугацаанд нь мэдээлэхэд оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Энэхүү бодлого нь “МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад хамаарна.

2.2. Компанийн дараах мэдээллийг танилцуулах, хүргүүлэх, мэдээлэхэд энэхүү бодлогыг баримтална. Үүнд:

- 2.2.1. Зохицуулагч байгууллын журмын дагуу хүргүүлж буй мэдээлэл, тайлан;
- 2.2.2. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийн хүрээнд хүргэх мэдээлэл;
- 2.2.3. Цахим хуудас болон албан ёсны facebook хуудасны мэдээлэл;
- 2.2.4. Жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээлэл.

2.3. Мэдээллийг дараах арга хэрэгслээр дамжуулан нээлттэй болгоно. Үүнд:

- 2.3.1. Компанийн албан ёсны цахим хуудаст байршуулах;
- 2.3.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл нийтлэх;
- 2.3.3. Олон улсын болон үндэсний арга хэмжээ, уулзалт;
- 2.3.4. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай болон бусад оролцогч талуудтай уулзалт зохион байгуулах.

3. Бодлогын үндсэн зарчим

3.1. Бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

3.1.1. Хариуцлагатай байх зарчим

3.1.1.1. Компани мэдээллийг бодит байдалд нийцсэн ил тод нээлттэй байлагхыг эрмэлзэж хариуцлагаа ухамсарлах;

3.1.2. Хууль тогтоомжийг дагаж мөрдөх зарчим:

3.1.2.1. Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журамд үндэслэн мэдээлэх;

3.1.3. Цаг тухайд нь мэдээлэх зарчим;

3.1.3.1. Компани нь мэдээллийг түгээхдээ үнэн зөв, хүртээмжтэй, цаг тухайд нь бүрэн дүүрэн тогтмол хүргэх;

3.1.4. Ойлгомжтой байх зарчим;

3.1.4.1. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх;

3.1.4.2. Хүргэж буй мэдээллийн агуулга нь үйл ажиллагааны зорилгод нийцсэн байх;

3.1.4.3. Тухайн мэдээлэл нь хөрөнгө оруулагчийн анхаарлыг татахуйц сонирхолтой эсэх;

3.1.5. Шударга байх зарчим;


3.1.5.1. Компанийн бизнесийн эрх ашиг сонирхол болон нээлттэй байх тэнцвэрийг хангах;

3.1.5.2. Хууль тогтоомж, дүрэмд өөрөөр заагаагүй бол аль нэг мэдээлэл хүлээн авагчид давуу эрх олгохгүй байх;

3.1.6. Нууцлалын зарчим.

3.1.6.1. Тухайн мэдээлэл нь ил болгож болох эсэх, материаллаг эсвэл нууцад хамаарах эсэхийг шалгах;

3.1.6.2. Хүний эрхийг хүндэтгэн үзэх;

 <p>МИК ХОЛДИНГ <small>ХУВЬСАЛАТ КОМПАНИИ</small></p>	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Мэдээллийн ил тод байдлын бодлого	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

3.1.6.3. Компанийн нууц мэдээллийг хамгаалахын зэрэгцээ хэрэглэгч, хамтран ажиллагсдынхаа нууцыг хадгалах.

4. Компанийн нэрийн өмнөөс мэдэгдэл хийх

4.1. Компанийн дараах албан тушаалтан компанийн нэрийн өмнөөс тайлбар өгөх, компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийнэ. Үүнд:

- 4.1.1. ТҮЗ-ийн дарга;
- 4.1.2. Гүйцэтгэх удирдлага;
- 4.1.3. Гүйцэтгэх захирлын томилсон албан тушаалтан болон хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан.

5. Нээлттэй болгох мэдээлэл

5.1. Нээлттэй болгох мэдээлэл гэдэг нь холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журмын дагуу ил тод, нээлттэй болгохоор заасан мэдээллийг ойлгоно.

5.2. Компани нь хууль, дүрэмд заавал нээлттэй болгох мэдээллээс гадна дараах мэдээллийг бэлтгэн нийтэд мэдээлнэ. Үүнд:

- 5.2.1. Компанийн стратеги, түүний зорилгод хэрхэн хүрэх тухай тайлбарыг багтаасан үйл ажиллагааны талаарх тайлан;
 - 5.2.2. Компанид шинээр гарч буй болон үндсэн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг тодорхойлохдоо ямар дүрэм журам баримталдаг, эрсдэлийг хэрхэн удирдах, бууруулах тухай;
 - 5.2.3. Эрсдэлийн аппетит;
 - 5.2.4. Засаглалын тайлан;
 - 5.2.5. Олон улсын стандартуудыг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх мэдээлэл;
 - 5.2.6. Нийгэм хариуцлага, байгаль орчны талаарх баримтлах бодлого;
 - 5.2.7. Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилт;
 - 5.2.8. Компанийн алсын хараа эрхэм зорилго;
 - 5.2.9. Компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлт;
 - 5.2.10. Компанийн засаглалын баримт бичиг.
- 5.3. Компани нь энэ бодлогын 5.2.1-5.2.7-д заасан мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайландаа заавал тусгасан байна.
- 5.4. Компани нь энэ бодлогын 5.2.8-5.2.10-т заасан мэдээллийг заавал компанийн албан ёсны цахим хуудаст заавал байршуулна.

6. Хувьцаа эзэмшигчид мэдээлэл өгөх

6.1. Компани нь хууль болон бусад дүрэм, журамд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж өгөх бөгөөд холбогдох хууль тогтоомж журмын дагуу энэ бодлогын 2.3-т заасан арга хэрэгслийг ашиглан мэдээллийг хүргүүлнэ.

7. Компанийн дотоод мэдээлэл

7.1. Дотоод мэдээлэл гэдэгт компанийн бизнесийн үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээлийн үнэ ханшид нөлөөлж болохуйц олон нийтэд нээлттэй бус, эцэслэн шийдвэрлэгдээгүй аливаа мэдээлэл хамаарна.

7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь дотоод мэдээллийг эзэмшигч, хариуцагч, хэрэглэгч байж болох бөгөөд тус мэдээллийг энэхүү бодлогын үндсэн зарчмаас гажууд байдлаар ашиг хонжоо олох, хэн нэгэнд давуу байдал олгох гэх зэргээр ашиглахыг хориглоно.

8. Хариуцлага

8.1. Энэхүү бодлогыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журам, гэрээ, контрактад заасны дагуу арга хэмжээ авна.

	“МИК ХОЛДИНГ” ХК	Төлөв: Батлагдсан
Мэдээллийн ил тод байдлын бодлого	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

9. Бодлогыг хэрэгжүүлэх

- 9.1. Бодлогыг хэрэгжүүлэхэд компаниас батласан холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 9.2. Энэхүү бодлогын хэрэгжилтийг компанийн ТҮЗ-ийн дэргэдэх засаглал хариуцсан хороо хариуцах бөгөөд эргэн хянаж нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл шинэчлэх шаардлагатай тохиолдолд төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтан болон газар нэгжээс санал авч ТҮЗ-өөс батлуулна.

____ 000 ____

★★

V

